

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.04.14

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Дональд Трамп өөрийн "Truth Social" хуудсаар дамжуулан ухаалаг гар утас, зөөврийн компьютер зэрэг цахим бараануудын зарим нь тариф чөлөөлөгдсөн гэх мэдээллийг няцаалаа.
- “Хэн ч шударга бус худалдааны өмнө хариуцлагаас мултрахгүй — ялангуяа Хятад улс бол бүр ч үгүй,” хэмээн Трамп нэмж хэлэв.
- Трамп энэ сард Хятадын бараа бүтээгдэхүүнд 145%-ийн тариф оноосны дараа энэ шийдвэр нь Хятадын үйлдвэрлэлд өндөр хамааралтай Apple (NASDAQ:AAPL) зэрэг томоохон АНУ-ын технологийн компаниудад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.
- Хятадын Худалдааны яамнаас мэдэгдсэнээр, АНУ-ын зүгээс зарим технологийн бүтээгдэхүүнд ногдуулсан тарифыг чөлөөлсөн нь "жигжиг алхам" боловч энэ нь хангалтгүй бөгөөд Трампын засаг захиргааг харилцан тарифыг бүрэн цуцлахыг шаардав.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.04.07-04.13

NASDAQ индексийн ханшийн таамаглал

Golomt_Capital published on TradingView.com, Apr 13, 2025 22:33 UTC-4



ЦАХИМ ХЭРЭГСЭЛД ТАТВАР НОГДУУЛНА

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп өөрийн "Truth Social" хуудсаар дамжуулан ухаалаг гар утас, зөөврийн компьютер зэрэг цахим бараануудын зарим нь тариф чөлөөлөгдсөн гэх мэдээллийг няцаалаа. Тэрбээр эдгээр бүтээгдэхүүнүүд "одоогийн 20%-ийн тарифын зохицуулалтад хэвээр хамрагдаж байгаа" хэмээн мэдэгдэв. Харин Баасан гарагийн орой Цагаан ордны зүгээс АНУ-ын Гааль, хил хамгаалах албаны шинэчилсэн удирдамжийг үндэслэн, ухаалаг утас, компьютер болон бусад технологийн эд ангиуд сүүлийн үеийн харилцан тарифын багцаас түр хугацаанд чөлөөлөгдсөн болохыг баталсан. Трампын тайлбарт дурдсанаар, эдгээр бүтээгдэхүүнүүд тухайн тарифын ангилалаас чөлөөлөгдөж өөр "тарифын ангилалд" шилжиж байгаа бөгөөд тун удахгүй хагас дамжуулагч болон өргөн хүрээний электроникийн нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой үндэсний аюулгүй байдлын судалгаа эхлэхийг анхааруулав. "Хэн ч шударга бус худалдааны өмнө хариуцлагаас мултрахгүй — ялангуяа Хятад улс бол бүр ч үгүй," хэмээн Трамп нэмж хэлэв. Өнөөдөр АНУ-ын Худалдааны нарийн бичгийн дарга Ховард Лутник зарим электрон бараа, тэр дундаа хагас дамжуулагч эд ангиуд ирэх сард тусгайлсан шинэ тарифын зохицуулалтад хамрагдах магадлалтайг мэдэгдэв. Энэ бүхэн Ерөнхийлөгч Трамп энэ сард Хятадын бараа бүтээгдэхүүнд 145%-ийн тариф оноосны дараа гарсан бөгөөд энэ шийдвэр нь Хятадын үйлдвэрлэлд өндөр хамааралтай Apple (NASDAQ:AAPL) зэрэг томоохон АНУ-ын технологийн компаниудад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй талаар анхаарал татаж байна. Гааль, хил хамгаалах албаны шинэчилсэн зааварт дурдсанаар, хагас дамжуулагч эд анги, нарны зай хураагуур, хавтгай дэлгэц, флаш диск, санах ойн карт зэрэг бүтээгдэхүүнүүд тодорхой хугацаанд тарифын хөнгөлөлтөд багтаж байна.

Цагаан ордны орлогч хэвлэлийн төлөөлөгч Күш Десай "Ерөнхийлөгчийн чиглэлийн дагуу эдгээр компаниуд АНУ-д үйлдвэрлэлээ аль болох хурдан шилжүүлэхээр шамдаж байна" хэмээн мэдэгдэв. Мөн тэрбээр "Ерөнхийлөгч Трамп АНУ Хятадаас хамааралтай байж болохгүй гэдгийг удаа дараа тодорхой илэрхийлсэн. Ялангуяа хагас дамжуулагч, чип, ухаалаг утас, зөөврийн компьютер зэрэг стратегийн ач холбогдолтой технологийг заавал дотооддоо үйлдвэрлэх шаардлагатай" гэв.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.04.07-04.13

ХОНГКОНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСЧ НЭЭГДЛЭЭ

Хятадын Худалдааны яам АНУ-ын тарифын чөлөөлөлтийг "жигжиг алхам" гэж нэрлэж, Ерөнхийлөгч Дональд Трампыг харилцан тарифыг бүрэн цуцлахыг шаардав.

Хятадын Худалдааны яамнаас мэдэгдсэнээр, АНУ-ын зүгээс зарим технологийн бүтээгдэхүүнд ногдуулсан тарифыг чөлөөлсөн нь "жигжиг алхам" боловч энэ нь хангалтгүй бөгөөд Трампын засаг захиргааг харилцан тарифыг бүрэн цуцлахыг шаардав. Хятадаас АНУ-д импортлогдож буй зарим бүтээгдэхүүнд одоогоор 145%-ийн татвар ногдож байгаа юм.

"Бид АНУ-ыг олон улсын хамтын нийгэмлэг болон дотоодын ухаалаг дуу хоолойг сонсож, хийсэн алдаагаа засах томоохон алхам хийхийг, 'харилцан тариф'-ын бүрүү үйлдлийг бүрэн зогсоож, харилцан хүндлэлд үндэслэсэн тэгш яриа хэлэлцээрээр зөрчилдөөнийг шийдвэрлэх зөв замдаа эргэн орохыг уриалж байна" хэмээн Хятадын Худалдааны яамны цахим мэдэгдэлд дурджээ (CNBC-ийн орчуулгаар).

Яамны мэдээлснээр, баасан гарагийн орой АНУ зарим технологийн бүтээгдэхүүнд тарифын чөлөөлөлт зарласны дараа Хятад улс энэхүү шийдвэрийн үр нөлөөг үнэлж эхэлсэн байна.

АНУ-ын дотоод ба олон улсын хариу үйлдэл

АНУ-ын Худалдааны төлөөлөгч Жэймисон Грип CBS News сүвгийн "Face the Nation" нэвтрүүлгээр "одоогийн байдлаар" Ерөнхийлөгч Трамп ба Хятадын дарга Ши Жиньпин нар утсаар ярих төлөвлөгөө байхгүй гэж мэдэгдэв. Тэрээр "Энэ асуудал бол удирдагчдын түвшний асуудал юм" гэж онцолсон.

Тарифын асуудалд Хятадын хариу үйлдэл төрийн болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд илэрч байна. Зарим чөлөөлөлтүүдийг Хятадын хэвлэл мэдээллүүд Трамп бууж өгч байна хэмээн тайлбарлаж, Хятадын нийлүүлэлтийн сүлжээг АНУ-ын компаниуд орлох боломжгүйг харуулж байна гэж онцолжээ.

"Олон нийтийн үзэл бодлоор АНУ-ын засаг тарифын бодлогоосоо дахин ухарч буй үйлдэл" хэмээн Бээжингийн албан ёсны "Beijing Daily" сонин мэдээлсэн байна.

Мөн Хятадын Weibo цахим платформ дээр "Трампын засаг дахин ухарч байна" гэсэн хаштаг тренд болж, хайлтын жагсаалтын хоёрдугаарт бичигджээ.

АНУ-ын Гаалийн болон Хил Хамгаалах албаны мэдээлснээр, Трампын засаг баасан гарагийн орой ухаалаг гар утас, компьютер, хагас дамжуулагч, нарны зайн эсүүд болон флэш диск зэрэг өргөн хэрэглэгддэг технологийн бүтээгдэхүүнүүдэд ногдуулсан тарифыг чөлөөлсөн нь Apple зэрэг Хятадад үйлдвэрлэлтэй томоохон технологийн компаниудад ихээхэн ашигтай шийдвэр болсон гэж үзэж байна.

Гэсэн хэдий ч CNBC-гийн өмнөх тайлангаас харахад, Хятадын бараа бүтээгдэхүүнд нийт 20%-ийн тариф одоогоор хэвээр байгаа ба энэ нь АНУ-ын эдийн засаг болон жигжиг бизнесүүдэд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хэвээр байна.



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS													
Most Anticipated Earnings Releases													
for the week beginning April 07, 2025													
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday					
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close				
	<div>LEVI</div> <div>LEVI'S</div> <div>PLAY</div> <div>WEEB</div> <div>CBX</div> <div>THE GREENBRIER COMPANIES</div>		<div>TLRY</div> <div>TILRAY</div> <div>WBA</div> <div>Walgreens Boots Alliance</div> <div>RPM</div> <div>RPM</div> <div>WDFC</div> <div>WD-40 COMPANY</div> <div>KRMN</div> <div>KARMAN SPACE & DEFENSE</div>		<div>CALM</div> <div>EM</div> <div>Cal-Maine Foods, Inc.</div> <div>MAMA</div> <div>Mama's CREATIONS</div> <div>AEHR</div> <div>AEHR</div> <div>KRUS</div> <div>KURA</div> <div>KRMN</div> <div>KARMAN SPACE & DEFENSE</div>		<div>DAL</div> <div>DELTA</div> <div>SMPL</div> <div>Simply Good FOOD COMPANY</div> <div>THTX</div> <div>THERA technologies</div> <div>NEOG</div> <div>NEOGEN</div>		<div>STZ</div> <div>Constellation Brands</div> <div>LAKE</div> <div>Lakeland INDUSTRIES, INC.</div> <div>PSMT</div> <div>PriceSmart</div> <div>RELL</div> <div>Richardson Electronics</div> <div>TBBB</div> <div>B BB</div>		<div>KMX</div> <div>CARMAX</div> <div>BYRN</div> <div>byrna</div> <div>LOVE</div> <div>LOVESAC</div> <div>NTIC</div> <div>NTI</div> <div>BSVN</div> <div>BANK</div>		<div>JPM</div> <div>JPMORGAN CHASE & CO.</div> <div>BLK</div> <div>BlackRock</div> <div>WFC</div> <div>WELLS FARGO</div> <div>BK</div> <div>BNY</div> <div>MS</div> <div>Morgan Stanley</div> <div>FAST</div> <div>FASTENAL</div>
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers					

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning									
		April 14, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
<div>GS</div> <div>Goldman Sachs</div> <div>MTB</div> <div>M&T Bank</div>	<div>APLD</div> <div>APPLIED BLOCKCHAIN</div> <div>FBK</div> <div>FirstBank</div> <div>PNFP</div> <div>Pinnacle FINANCIAL SERVICES</div> <div>SKIL</div> <div>skillsoft</div> <div>KMTS</div> <div>kestra</div> <div>OTRK</div> <div>Ontrak health</div> <div>HIT</div> <div>hi+ health in tech</div> <div>BSEM</div> <div>BioStem TECHNOLOGIES</div>	<div>BAC</div> <div>BANK OF AMERICA</div> <div>C</div> <div>citi</div> <div>JNJ</div> <div>Johnson & Johnson</div> <div>PNC</div> <div>PNC</div> <div>ACI</div> <div>Albertsons Companies</div> <div>ERIC</div> <div>ERICSSON</div> <div>RENT</div> <div>RENT THE RUNWAY</div> <div>ZBAO</div> <div>致保科技 Zhibao Tech</div>	<div>UAL</div> <div>UNITED</div> <div>IBKR</div> <div>Interactive Brokers</div> <div>JBHT</div> <div>J.B. HUNT</div> <div>HWG</div> <div>WATCO</div> <div>FULT</div> <div>FULTON FINANCIAL CORPORATION</div> <div>EQBK</div> <div>EQUITY BANCSHARES, INC.</div> <div>KORE</div> <div>GAME</div> <div>GAMESQUARE</div> <div>PPSI</div> <div>PIONEER POWER SOLUTIONS</div> <div>OMC</div> <div>OmnicomGroup</div>	<div>ASML</div> <div>USB</div> <div>us bancorp</div> <div>ABT</div> <div>Abbott</div> <div>PGR</div> <div>PROGRESSIVE</div> <div>TRV</div> <div>TRAVELERS</div> <div>PLD</div> <div>PROLOGIS</div> <div>MOV</div> <div>MOYADO GROUP INC</div> <div>ALV</div> <div>Autoliv</div> <div>CFG</div> <div>Citizens Financial Group, Inc.</div> <div>FHN</div> <div>FIRST HORIZON NATIONAL CORPORATION</div>	<div>AA</div> <div>Alcoa</div> <div>OZK</div> <div>Bank OZK</div> <div>HOMB</div> <div>Home Depot</div> <div>CSX</div> <div>CSX</div> <div>KMB</div> <div>KINDER MORGAN</div> <div>SNV</div> <div>SYNOVUS</div> <div>GSBC</div> <div>GREAT SOUTHERN BANK</div> <div>REXR</div> <div>Roxford Industrial</div> <div>SFNC</div> <div>Simmons Bank</div> <div>SLG</div> <div>ISL GREEN REALTY CORP</div>	<div>TSMC</div> <div>UNH</div> <div>UNITEDHEALTH GROUP</div> <div>HBAN</div> <div>Huntington</div> <div>AXP</div> <div>AMERICAN EXPRESS</div> <div>RF</div> <div>REGIONS</div> <div>TCB</div> <div>TEXAS CAPITAL BANK</div> <div>DHI</div> <div>D.R. HORTON</div> <div>ALLY</div> <div>ally</div> <div>HOFT</div> <div>HOOKER</div> <div>FIFB</div> <div>FIFTH THIRD BANK</div>	<div>NFLX</div> <div>NETFLIX</div> <div>MRTN</div> <div>MARTEN</div> <div>INDI</div> <div>INDEPENDENT BANK</div>				
http://eps.sh/cal		© 2025 Earnings Whispers									